

**ЭНГИЙН ПАСПОРТ БҮХИЙ ИРГЭДИЙГ ХАРИЛЦАН ВИЗЭЭС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Тайландын Вант Улсын Засгийн газар /цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэх/,

Бангкок хотноо 1994 оны хоёрдугаар сарын 25-ны өдөр байгуулсан “Дипломат болон албан паспорт бүхий иргэдийг харилцан визээс чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Тайландын Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг удирдлага болгон,

Хоёр орны хоорондын нөхөрсөг харилцааг улам хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хэлэлцэн тохирогч Талуудын энгийн паспорт бүхий иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор,

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүчин төгөлдөр энгийн паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, оршин суух, гарах болон дамжин өнгөрөхдөө Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт орсон өдрөөс хойш 30 хоногоос илүүгүй хугацаагаар байж болно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүчин төгөлдөр энгийн паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 30 хоногоос илүү хугацаагаар байх бол урьдчилан виз авна.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүчин төгөлдөр энгийн паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт олон улсын зорчигдод нээлттэй боомтоор нэвтэрнэ

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын хүчин төгөлдөр энгийн паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа түүний хууль дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

Тавдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагын Хэлэлцэн тохирогч Талын тааламжгүй гэж үзсэн иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах эсхүл байх хугацааг богиносгох буюу хүчингүй болгох эрхийг хөндөхгүй.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэхүү Хэлэлцээрийг үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийм арга хэмжээ авсан буюу үйлчлэлийг дахин сэргээсэн тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар даруй мэдэгдэнэ.

Долдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш 30 хоногоос илүүгүй хугацааны дотор паспортын загварыг дипломат шугамаар харилцан солилцоно.

Хэлэлцэн тохирогч Талууд шинэ паспорт хэрэглэх буюу засвар оруулсан тухайгаа уг баримт бичгийг хэрэглэж эхлэхээс 30 хоногийн өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

Наймдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр гарын үсэг зурснаас хойш 30 дахь өдөр хүчин төгөлдөр болох бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал хүчингүй болгох тухай бичгээр гаргасан саналаа дипломат шугамаар мэдэгдсэнээс хойш 90 дэх өдөр хүртэл хүчинтэй байна.

Хэлэлцэн тохирогч Талууд ноот бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Энэхүү Хэлэлцээрийг Бангкок хотноо 2007 оны 12 дугаар сарын 14-ны өдөр англи хэлээр хоёр хувь байгуулав.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг